

“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын
04-ний өдрийн 23/01а/01 тоот тооллын Хавсралт 6”



“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг бэлдэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Залгамж халааны тухай ойлголт

- 2.1 ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халаа гэдэг нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын орон тоо гарсан тохиолдолд тэдний оронд сонгох хүний нөөцийг ойлгоно.

Гурав. Залгамж халааг бэлдэх бодлого

- 3.1 ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааг бэлдэхдээ дараах чиглэлүүдээр ажиллана. Үүнд:
- 3.1.1 Салбарын шилдэг мэргэжилтнүүд, салбарын чиглэлээр мэргэшсэн хуульчид, мэргэшсэн нягтлан бодогчдын судалгааг гаргаж, тэдэнтэй ажил хэргийн холбоо харилцаа тогтоох, энэхүү судалгааг байнга шинэчлэж байх;
 - 3.1.2 Жил тутамд уламжлал болгон харилцагчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг түнш байгууллагууд зэрэгтэй уулзалт зохион байгуулж, салбарын шилдэг мэргэжилтнүүдийг урьж оролцуулах замаар тэдэнд компанийн үйл ажиллагааг танилцуулж байх;
 - 3.1.3 Салбарын хэмжээнд зохион байгуулагддаг олон нийтийн арга хэмжээ, эвент, танилцуулга уулзалт зэрэгт байнга оролцож, нэтворкинг хийх;
 - 3.1.4 Хүний нөөцийн бүрдүүлэлт хийдэг мэргэжлийн компаниудтай харилцаа холбоо тогтоож, тэдгээрээр дамжуулан нөөцөө бүрдүүлэх;
 - 3.1.5 Компанид ажилладаг шилдэг мэргэжилтнүүд дотроос цаашид ТУЗ-д ажиллуулах боломжтой хүмүүсийн судалгаа гаргаж, тэднийг сургах, дадлагажуулах бодлого баримтлах;
 - 3.1.6 Тухайн салбартаа үйл ажиллагаагаараа шилдэг, олны танил, нэр хүнд сайтай, этик ёс зүйтэй мэргэжилтнийг урьж ажиллуулах боломжтой.
- 3.2 Гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халааг бэлдэхдээ дараах чиглэлүүдээр ажиллана. Үүнд:
- 3.2.1 Компанийн ажилтнуудаас дэвшүүлэн ажиллуулах боломжтой түлхүүр ажилтнуудын судалгаа гаргаж тэднийг сургах, дадлагажуулах тусгай хөтөлбөр гарган бэлдэх;

- 3.2.2 Банк, санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлагатай мэргэжилтэн, экспертийг шууд урьж ажиллуулах;
- 3.2.3 Компанийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжилтэн бэлддэг их дээд сургуультай харилцаа холбоо тогтоон тэдний шилдэг суралцагсдаас сонгон, компани дээр дадлага хийлгэх, компанийн дотоод сургалтын хөтөлбөрийн дагуу компанийн үйл ажиллагаатай танилцуулж, бэлтгэх бодлого баримтлах;
- 3.2.4 Энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд үндэслэн компанийн гүйцэтгэх дээд удирлагад ажиллах боломжтой мэргэжилтний судалгаа гаргаж, ажил хэргийн холбоо харилцаа тогтоох

Дорov. Залгамж халааг компани дээр бэлдэх хөтөлбөр хэрэгжүүлэх

- 4.1 Компани дээр залгамж халааг бэлдэх хөтөлбөртэй байна.
- 4.2 Энэ журмын 4.1-д заасан хөтөлбөрт дараах асуудлыг тусган хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.2.1 Компанийн үйл ажиллагааны онцлог, стратеги тактик;
 - 4.2.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт олон улсын хэмжээнд гарч буй шилдэг туршлага, шинэ хандлага;
 - 4.2.3 ТУЗийн үйл ажиллагааны чиглэл, ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлага;
 - 4.2.4 Компанийн удирдах ажилтанд тавих шаардлага
- 4.3 Гадаад, дотоодод шаардлагатай чиглэлээр явагдаж буй сургалтад хамруулах.

Тав. Албан тушаал дэвшүүлэн ажиллуулах

- 5.1 ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох шаардлага гарсан тохиолдолд энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн дотор тухайн орон тоонд хамгийн тохиромжтой гэсэн хүмүүст ТУЗ-д ажиллах урилга хүргүүлнэ.
- 5.2 Урилга хүлээн авсан этгээд ТУЗ-д ажиллахаар зөвшөөрсөн тохиолдолд түүний нэрийг ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан сонгуулах бодлого баримтална.
- 5.3 Гүйцэтгэх удирдагын дээд албан тушаалтны орон тоо гарсан тохиолдолд эхний ээлжинд компанид ажиллагсдаас дэвшүүлэн ажиллуулах бодлого баримтална..
- 5.4 Компанид ажиллагсдаас тохиромжтой этгээд байхгүй байгаа тохиолдолд энэ журмын 3.1.1-д заасан судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдээс тохиромжтой этгээдийг сонгон урилга хүргүүлэх замаар сонгон ТУЗ-ийн хуралдаад танилцуулж сонгох зарчим баримтална.

Зургаа. Бодлогын хэрэгжилтийг хангах

- 6.1 Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах ажиллагааг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны удирдлага чиглэлийн дагуу компанийн хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.